

Японоос олдсон Угийн бичигийг Монголынхтой зэргэцүүлэн судласан нь

Б.Сумьяабаатар(IUU.Чингис Хаан судлалын хүрээлэн)

- Угийн бичиг бол хүн төвт Монгол түүхийн сурвалж
- Угийн бичиг бол Монголчуудын бахархлын бичиг
- Японд, Сэцэн хан Шолойн Угийн бичиг олдсон нь
- Японд олдсон Сэцэн хан Шолойн Угийн бичгийг

Монголынхтой зэргэцүүлэн судласан нь

Угийн бичиг бол хүн төвт Монгол түүхийн сурвалж – } эдгээрийн тухай өгүүлснийг

Угийн бичиг бол Монголчуудын бахархлын бичиг } товчлов


Японд олдсон Сэцэн хан Шолойн Угийн бичгийг Монголынхтой зэргэцүүлэн судласан нь

- Японд, Чингис хааны удмынханы 子孫 гэрийн үеийн бичмэл 家系 олдсон тухай NHK телевизээр нэвтрүүлж, монгол улсын Н.Нарангэрэл, Г.Мөнх-Эрдэнэ, П.Батчулуун, Т.Төрбат, Д.Болормаа, Sogoо нарын олон хүн санал бодлоо хуваалцан нийтэд түгээжээ. 1962 оноос монголчуудын Угийн бичиг, Гэрийн үеийн бичмэлийг судлаж ном бүтээл, цөөн бус өгүүлэл нийтлүүлсэн миний бие ихэд сонирхож, зэргэцүүлэн судлахаар сэтгэл шулуудав. Японд олдсон нь Сэцэн хан Шолойн Угийн бичиг бөгөөд, Монгол улсын үндэсний номын санд хоёр хувь (дансны дугаар 79346\7994 ба 79347\695), Архивд нэг хувь байдаг.

Сэцэн хан Шолойн Угийн бичгийг Монгол улсад анх судалж, хэвлэсэн байна.

«Чингисийн алтан ургийн Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл»(Улаанбаатар. 2005 он)ээс эшлэе:

Сэцэн хан аймаг



Гэрийн үеийн бичмэл.79347.

Аймаг : Qalq-a-yin Sečen qan ayimaγ

Халхын Сэцэн Хан аймгийн хил хязгаар нь, дорно этгээд Эрдэнэ уулаар Хар мөрөн мужийн Хөлөнбуйртай ; Өмнө этгээд Тарган Чандмань(Цайдам), Бага элсэн манхан, Өвөр монголын Шилийн голын чуулганы хуучид, авга,авга нар хошуутай ; Баруун этгээд цагаан чулуут ; умар этгээд Орос улсын Байгалын сав газар, зүүн Шибэртэй ; Зүүн өмнөд Шилийн голын чуулганы үзэмчин хошуутай, баруун урдуураа Халхын Түшээт Хан аймагтай тус тус зах нийлж байв.

Халхын Сэцэн Хан аймагт өнөөгийн Хэнтэй, Сүхбаатар, Дорнод аймгийн нутаг, Дорноговь, Дундговь, Төв аймгуудын нутгийн зарим хэсэг багтаж байв.

Сэцэн Хан аймагт Егүзэр хутагт, Ялгуулсан хутагт хэмээх шавь захирсан тамгатай хутагт хамаарагдаж байсан. Сэцэн Хан аймгийн сүүлчийн хан нь НаваанНэрэн (зарим бичигт Наваанцэрин гэсэн байдаг) байв.

Суурин : Sečen qan Šoloi-гоор эхлэсэн.

Үе : 12 үе

Хүний тоо : (79347\695) 3673 + (79346\7994) 8978+5=12656 хүн

Миний бие 79347\695 дугаар бүхүй гэрийн үеийн бичмэлийг 1964 он, 1985 оны 12 сар, 1986 оны 11-р сард номын санд сууж, 8-р үеийг нь хүртэл 3673 хүний нэрийг уг эхээс худам монголоор буулгаж авч, 2000 оны 03 сараас мөн оны 04 сарын 15 хүртэл латин галигт буулган оюутласан. Саяхан, олон сар номын санд сууж байж 79346\7994 дугаар бүхүй Угийн бичгийг латин үсгээр галиглан оюутад шингээв.

Онцлог : ∞ Гэрийн буйрын чинээ цагаан цуу ямбуун дээр хар бэхээр бичсэн. Дундуураа зүйдэлтэй.

Их бага 14 цагриг зурсан ба 12 нь хүний нэртэй. Өөрөөр хэлбэл 12 үе гэрийн үеийн бичмэл.Үлгэрлэвээс



□ □ □ Төвийн дугуйд, тухайлбал, тоононд нь

∨ ∨ " Сэцэн хан Шолой " гэж бичсэн.

○ ○ ○ / \ Халз дор нь тэргүүлсэн хөвүүнийг оноож
 / \ бичсэн. Нэрсийг дээрээс доош, хүүхдүүдийг зүүн гараас баруун гар
 □□□□ тийш тойруулан бичсэн. Ахмад хөвүүн нь зүүн гартаа гэсэн үг.

□ бинтийг хул шар бэхээр тавьж, хүний нэрсийг хар бэхээр бичсэн байна.

№ Уул гэрийн үеийн бичмэл номын санд 79347/695 гэсэн дансны дугаартай байгаа ба
 5852 дансны дугаарт буй гэрийн үеийн бичмэлтэй төстэй. Цагаан цуу ямбуу дээр бичсэн.
 (79347/695) гэрийн үеийн бичмэл бороонд норж, зарим хэсэг нь урагдаж өмөрч ойчсон байх тул 5852
 зэрэг гэрийн үеийн бичмэлийг ашиглан, өмөрч алга болсон хэсгийг нөхөх шаардлагатай. 79347/695
 дугаар бүхүй гэрийн үеийн бичмэл нь маш дэлгэрэнгүй. Харин 5852 дугаар бүхүй гэрийн үеийн бичмэлд
 Шолойн хэргэм зэргийг их тодорхой бичсэн байх тул сүүл үеийнх бололтой. Гэрийн үеийн бичмэлүүд-
 ийг латин галигаар буулгаж давхар ажил удах нь, нэгдүгээрт, дэлхий нийтээр манай гэрийн үеийн
 бичмэлүүдийг үзэж сонирхоход хэрэгтэй. Хоёрдугаарт, гэрийн үеийн бичмэлүүдийг байгаа эхээр нь буюу
 худам монголоор оюутлаж(компьютерлэж) болох боловч, худам монголоор хүний нэрсийг цагаан толгойн
 дэсэд оруулах (sort хийх) түвшинд хараахан хүрээгүй байгаатай холбоотой. Техникийн дэвшилийн
 түвшин шинжлэх ухаанд ийм их ач холбогдолтой аж. Хүний нэрийн бүгд хэлхээгүй бол хэрэгцээт нэрээ
 хайж олж чадахгүй тул ямар ч ашиггүй. Иймийн учир, арга буюу латин галигт оруулж нүсэр их ажил
 хийх болсон. Хүний нэрсийг латинаар галиглаад, ард нь залган худам монголоор галиглаж нэг мөрнөө
 бичсэний хойно, түүнийгээ sort хийж цагаан толгойн дэсэд оруулаад, дараа нь латин галигийг нь
 арилгаж худам монгол бичгийг нь үлдээж болох нэг арга бий. Гэхдээ энэ нь худам монгол цагаан
 толгойн дэс дараа биш, мөн л латин галиг үсгийн дэс болох учир тийн давхар ажил болгосонгүй, шууд
 латин галигаар үйлдсэндээ хүлцэл өгсү. Сүүлийн хэвлэлд, нэрсийн хэлхээг монгол, латин, шинэ үсгээр
 хийж өгсөн.

№ Уул гэрийн үеийн бичмэл нь Шолойгоор эхлэж байна. Шолой нь Бөрт Чоноос 41-р үеийн хүн
 (1627-1655) бөгөөд 40-р үеийн Moogu Boyima(1-40-864), 39-р үеийн Amin Dural(1-39-786),
 38-р үеийн Gersengj e(1-38-749)-ээр дамжин 37-р үеийн Батмөнх даян хан(1-37-712)-тай залгаг-
 дана.

№ Эцэг, хөвүүн хоёрыг □ ...дүгээр хөвүүн гээд ард нь бинт тавьж, цол, хэргэм, зэргэ, тушаалыг
 дурдаж, дахин бинт тавьж нэрийг бичиж □ холбосон байна.

№ Шолойн ахмад хөвүүнийг зарим гэрийн үеийн бичмэлд Mečiri ilding tüsiyetü(seč1-42-1) гэсэн
 байх ба энд Mičiri гэж бичсэн нь тод харагдаж байна.

№ Mečiri ийн ахмад хөвүүнийг зарим гэрийн үеийн бичмэлд "Radna,т Радна" гэсэн байх ба энд
 харин Arana гэж бичсэн нь тод харагдаж байна. Мөн хоёрдугаар хөвүүнийг нь Šabari, Šeberi,
 заримдаа Šaburi Erdeni, Šebüri Erdeni, заримдаа цуг бичсэн ч байдаг. Тэр бүгдийг засч нэг мөр
 болгоогүй. Байгаа байгаа чигээр нь хуулж, тайлбарлан толилуулах нь эхбичигсудлалын зарчим.
 Энэ нь бусад гэрийн үеийн бичмэлүүдэд ч хамаарна гэдгийг тэмдэглэе.

№ Нэг хүний нэрийг заримдаа хэвтээ, заримдаа босоо -д-гээр бичсэн зүйл бий, жишээ нь, Шолойн
 аравдугаар хөвүүн Дашийг Dasi гэлгүй dasi(79347-42-11) гэж бичсэн. Мөн dasi(79347-47-1866),
 dasi(79347-47-1888); Damba ийг damba(79347-44-212); Delger ийг delger(79347-47-2162); Dampil
 ийг dampil(79347-47-2191) гэж бичсэн тохиолдоно.

№ Mičiri-yin qoyadıyar köbegün Šaj ei erke j ayisang(seč1-43-3), Šaj ei~Sej ei(79347-42-14) гэсэн бичлэгтэй.

№ j ийг шилбээр бичсэн: Dangj in(79347-43-30), Wangj il(79347-43-42)

№ Дэвсгэрлэн орсон -ү ийн өмнө хоёр цэг тавьсан, ж.: j asay, Wangčuy(79347-43-43)

№ Šebden(79347-42-8)ийн долдугаар хөвүүнийг Seblel~Sablal(79347-43-41) аль алианаар нь уншиж
 болохоор байна.

№ Rinčen гэдэг нэрийг Эрдэнэ, Rinčin(79347-43-20), Ringčin(79347-44-136), Erinčin (79347-43-46)
 гэх зэргээр бичсэн.

№ Лхамцог гэдэг нэрийг Lhamučoy(79347-47-1824), Lhamčoy(79347-47-1763) гэх зэргээр ялгаатай
 бичсэн.

№ Нэг нэрийг хэд хэдэн янзаар бичсэн зүйл нэлээн бий. Түүнийг дураар засч нэгмөр болгоогүй. Уул
 эхдээ ямар байгаагаар нь хуулах нь зүй. Жишээлбэл, Дамрин гэдэг нэрийг Damirin, Damiran,
 Damarin; Idam, Idama, Idam-a; Bayingj ur, Bayingj uur; Lombo, Lomboo; Šebel, Šebil, Čibil гэх зэрэг.
 Мөн, нэг нэрийг Čendorj i, Čedengdorj i гэж хоёр өөр биччихээд, тэр нь нэг айлын хоёр
 хүүхдийг ялгасан тохиолдол ч бий, Жишээнь,
 Gongsürünj ab(79347-45-621)...o j asay o Čendorj i(79347-46-1493)
 ... o Čedengdorj i(79347-46-1495)

№ Arana[Radn-a](79347-43-13)ийн дөрөвдүгээр хөвүүнийг зарим гэрийн үеийн бичмэлд Nilaq-a гэсэн
 байх ба энд Nilq-a(79347-44-70) гэж бичжээ.

№ güng-ün гэдэг үгийг güng-ni гэж бичсэн, жишээлбэл, o güng-ni j erge j asay o ČenggÜnj ab

(79347-44-143). Ташаарсан юм болов уу гэсэн чинь, ° gūng-ni j erge j asay° Yündünčeweng (79347-45-494), Güngsengbambar(79347-46-1263) гэж дахин гарч байна.Тэгэхээр тийн бичдэг ёс байжээ гэж үзэхээс аргагүй нь.

⌘ Нэгдүгээр үеэс хойш орсон -ü ийг урт шилбэтэй бичсэнийг том -Ü гээр тэмдэглэв, жишээ нь: ČenggÜnj ab(79347-44-143), Rabj Ün(79347-44-201), BatutÖrү(7947-47-3024)

⌘ Хавсармал нэрийн хоёрдугаархи нь эгшгээр эхлэсэн байвал хам бичсэн байна.Үүнийг том үсгээр бичиж ялгаж өглөө, жишээ нь, GünggeOdser(79347-45-505), Batultegel[Batu-Itegel](79347-47-2275), BatuErdeni(79347-47-2447), EngkeAmur(79347-47-2473), Baj arAyusi(79347-47-2477),ČedengIsi(7947-47-2966), BatuErdeni(7947-47-3045), ČewengOyidub(7947-48-3137), ČeberErdeni(79347-48-3590).

⌘ "Охин" гэдэг үгийг ökin(79347-44-112), okin(79347-381) гэж хоёр янз бичсэн.

⌘ Зарим хэсэг урагдаж алга болсон ба [...dob](79347-44-184) л харагдаж байна. 44-р үеийн Чойжамцын 6,7,8,9,10-р хөвүүдийн нэрсийг бичсэн хэсэг урагдан тасарч алга болсон байна. Эцэг ба хөвүүдийнх нь үлдэж хоцорсон тул өөр гэрийн үеийн бичмэлүүдээс нөхөн сэргээж болох талтай, үүнд,° Čam[]~Čem[](79347-45-359)нь Цэвдэн, Донёд, Санжай гэсэн гурван хөвүүнтэй; ° Jam[](79347-45-360)нь Бирва гэдэг гагц хөвүүнтэй; ° Ča[]~Če[](79347-45-361) нь Иш гэдэг ганц хөвүүнтэй; ° Do[](79347-45-362) нь МэндОчир гэдэг гагц хөвүүнтэй; ° [](79347-45-363) нь Гомбо,Чойнжур, Соном гэдэг гурван хөвүүнтэй.

Мөн 46-р үеийн 739 дугаарт бүхүй Вамбү-гээс 752 дугаарт бүхүй Amursana(79347-46-752) хүртэл уул гэрийн үеийн бичмэл бороонд норж,урагдан тасарч үгүй болсон хэсэгтэй. Энэ хэсгийг бусад гэрийн үеийн бичмэлүүдтэй зэргэцүүлэн үзэж нөхөх, нягтлах шаардлагатай.

⌘ Энэ нэрийг Lider гэж уншиж болох авач, Йөншөбү Ринчен багш, насан өөд болохынхоо өмнөхөн оросоор бичиж, Монголын судлал цувралд хэвлүүлэхээр өгсөн боловч Главлитийн босгыг давж чадаагүй " Сказители и сказочники у монголов " гэдэг алдарт зохиолд " Лидар сэцэн " гэдэг нэр олонтаа гардаг тул, Lidar(79347-45-319) гэж буулгалаа. Энэ зохиолыг мөхөс хүн мөдхөн хэвлүүлэх болно.

⌘ Нэр ижилсүүлэх нь, үсгээр ба үеэр толгой холбох; сүүл холбох; хавсарсан нэрсийг авиагаар ба утгаар ижилсүүлэх гэх мэт хэд хэдэн янз байдаг. Жишээлбэл,Эрдэнэ, Радна, Ринчин гэх буюу, Darj iy-a(79347-46-1188)...° Tegüsčoytu(79347-47-2376)

...° Delgerčoytu(79347-47-2377)

...° Bayangčoytu(79347-47-2378)

Yüm(79347-46-1229)...° Dobdondorj i(79347-47-2420)

...° Dongdubdorj i(79347-47-2421)

...° Dongyoddorj i(79347-47-2422)

Demčüg(79347-46-1237)...° Mabumdorj i(79347-47-2431)

...° Gengdündorj i(79347-47-2432)

...° Gombudorj i(79347-47-2433)

...° Jangčubdorj i(79347-47-2434)

Čedenj ab(79347-46-1501)...° Langgünj ab(7947-47-2843)

...° Gombuj ab(7947-47-2845)

...° Čoyij unj ab(7947-47-2846)

...° Lhamuj ab(7947-47-2847)

Pungčuy(79347-46-1523)...° Gombudorj i(7947-47-2885)

...° Gongčuydorj i(7947-47-2886)

...° Čedübdorj i(7947-47-2887)

Čerin(79347-46-1525)...° Čimeddorj i(7947-47-2888)

...° Gongčuydorj i(7947-47-2889)

...° Samdandorj i(7947-47-2890)

Čeden(79347-46-1529)...° Gongčuydorj i(7947-47-2893)

...° Čimeddorj i(7947-47-2894)

...° Samdandorj i(7947-47-2895)

Dawa(79347-46-1530)...° Čedendorj i(7947-47-2896)

...° Gombudorj i(7947-47-2897)

...° Sangdubdorj i(7947-47-2898)

Idam(79347-47-1795)...° Čibayj ab(7947-48-3295)

...° Dasij ab(7947-48-3296)

...° Darmaј ab(7947-48-3297)

...° Tegüsј ab(7947-48-3298)

...° Wačirј ab(7947-48-3299)

Нэр ижилсүүлэхдээ ив ижил нэр өгсөн нь цөөнгүй. Монголчууд түүнийгээ их, бага, дунд хэмээн

ялгадаг заншилтай. Энэ нь дээр үеийн уламжлал аж. жишээ нь
Senggepil(79347-46-1533)...◦ Čeden(7947-47-2901)
...◦ Čeden(7947-47-2902)
Gangj ur(79347-46-1560)...◦ Gongčuyj ab(7947-47-2943)
...◦ Gongčuyj ab(7947-47-2945)
Lubsangdorj i(79347-47-1722)...◦ Jamsaran(7947-48-3192)
...◦ Jamsaran(7947-48-3193)
Čerindorj i(79347-47-1990)...◦ Jamsarin(79347-48-3546)
...◦ Jamsarin(79347-48-3547)
Jigmed(79347-46-1369)...◦ Jamsarin(7947-47-2629)
...◦ Jamsarin(7947-47-2632)
Mangj ilj ab(79347-47-1736)...◦ Pungčuydorj i(7947-48-3215)
...◦ Pungčuydorj i(7947-48-3216)
...◦ tayij i-ača bayilyaysan◦ Pungčuydorj i(7947-48-3217)
Dasidondub(79347-46-1439)...◦ Pungčuydorj i(7947-47-2743)
...◦ Pungčuydorj i(7947-47-2745)
Dobčin(79347-47-1741)...◦ Dasij ab(7947-48-3226)
...◦ Dasij ab(7947-48-3227)
Lhamčoy(79347-47-1763)...◦ Sonom(7947-48-3260)
...◦ Sonom(7947-48-3262)
Gongčuy(79347-47-1915)...◦ Dawa(79347-48-3450)
...◦ Dawa(79347-48-3451)
Bimpil(79347-47-1975)...◦ Gombuj ab(79347-48-3533)
...◦ Gombuj ab(79347-48-3534)
Wangdanj ab(79347-46-1502)...◦ Gombuj ab(7947-47-2849)
...◦ Gombuj ab(7947-47-2851)
Čerinj ab(79347-46-1503)...◦ Gombuj ab(7947-47-2855)
...◦ Gombuj ab(7947-47-2858)
Gürüj ab(79347-46-1314)...◦ Gombuj ab(79347-47-2537)
...◦ Gombuj ab(79347-47-2538)
Čimed(79347-46-1318)...◦ Gombuj ab(79347-47-2544)
...◦ Gombuj ab(79347-47-2545)
Batu(79347-46-1521)...◦ Gongčuydorj i(7947-47-2882)
...◦ Gongčuydorj i(7947-47-2883)
Wangčinj ab(79347-46-1401)...◦ Gongčuy(7947-47-2668)
...◦ Gongčuy(7947-47-2673)
Orčinj ab(79347-46-1477)...◦ Čibayj ab(7947-47-2810)
...◦ Čibayj ab(7947-47-2811)

■ Нэр ижилсүүлэхдээ зөвхөн хүүхдүүдийнхээ нэрийг хооронд нь ижилсүүлээд зогсохгүй, эцэг хөвүүн хоёр ижил нэртэй байх нь цөөнгүй, жишээлбэл
Gombuj ab(79347-47-1692)ийн хөвүүн ◦ j asay◦ Gombuj ab(7947-48-3160)
Gombuj ab(79347-47-1759)ийн хөвүүн ◦ Gombuj ab(7947-48-3254)
Gombuj ab(79347-47-1964)ийн хөвүүн ◦ Gombuj ab(79347-48-3513)
Dangj in(79347-47-1993)гийн хөвүүн ◦ Danj in(79347-48-3555)

■ 47-р үеийн Доржжавыг Дүнхэр хутагтад шавь болгожээ гэсэн тэмдэглэл бий.
◦ Dorj ij ab(7947-47-2686)[Düngkür qutuγtu-du šabi bolγaj ai]. Дүнхэр хутагт гэдэг нь 46-р үеийн Idamj ab(79347-46-1420)ын хоёрдугаар хөвүүн Цэдэнжав байна.◦ düngkür qutuγtu
◦ Čedenj ab(7947-47-2706).

46-р үеийн Чойжинжавын хөвүүн Иш-Ойдовжамцан гэдэг хүнийг Жавзандамба хутагтад шавь болгосон тухай тэмдэглэл бий. Čoyij ungj ab(79347-46-1492)...◦ IsiOyidubj amčan(7947-47-2831) [Jibj ungdamba qutuγtu-du šabi bolγaj uqui]. Мөн, 46-р үеийн Ванданжавын хөвүүн Гончигжав гэдэг хүнийг Жавзандамба хутагтад шавь болгосон тухай тэмдэглэл бий.
Wangdanj ab(79347-46-1502) Gongčuyj ab(7947-47-2852) [egün-i Jibj undamba-du šabi bolγaj uqui].

■ Гэрийн үеийн бичмэлийг засцагаан үйлдэж, хэвдүүлж хянан нягталахдаа алдаа мэдгийг шууд баллаж сохолж, дээр дээрээс нь дарж бичдэггүй. Шүүдэглэгч, бурууг засахдаа дээр нь цаас наагаад нямбайлан засч бичдэг. Жишээ нь: Taulai гэж бичсэнийг дээр нь цаас наагаад Dayulai (7947-48-3310) болгожээ. Bendege гэж бичсэнийг дээр нь цаас наагаад Badai(7947-48-3315) болгожээ. Lompil(79347-48-3522)ийг [Nompil] болгосон.

ᠮ Монголоор бичсэнийг сайтар ажиглахгүй бол, ташаа уншиж болохоор нэлээн зүйл байдаг, жишээлбэл, Баяр ба Базар(*урт шилбээр бичсэн тохиолдолд*), Аюуш ба Аюухи - Ayusi(79347-47-2025)...о Ayuki(79347-48-3617) гэх мэт олон.

ᠮ Хэрхэн залган уншихыг дахин сануулбал :

□ □ ▶ Šoloi(1-41-979)... aqamad köbegün° **Mičiri**(79347-42-2)
... qoyaduyar° **Čeberi**(79347-42-3)
... yurbaduyar° **Labari**(79347-42-4)

... dörbedüger° **Bumba**(79347-42-5)
... tabuduyar° sečen qan° **Babu**(79347-42-6)
... j iryuduyar° **Čoskib**(79347-42-7)
... doluduyar° beyise° **Čebden**(79347-42-8)
... nayimaduyar° **Badmadasi**(79347-42-9)
... yisüdüger° beyise° **Anangda**(79347-42-10)
... arbaduyar° **dasi**(79347-42-11)
... arban nigedüger° beyile° **Budaĭ ab**(79347-42-12)

42 нь Бөртчоноос 42-р үе гэсэн үг. Šoloi(1-41-979) нь, Бөртчоноос 41-р үеийн Шолой, хувийн дугаар нь 979 гэсэн үг(*энэ дугаар давтагдахгүй*). aqamad köbegün° **Mičiri**(79347-42-2) гэсэн нь, түүний ахмад хөвүүн, Бөртчоноос 42-р үеийн Мичири, 79347-р гэрийн үеийн бичмэлд хувийн дугаар нь 2 гэсэн үг гэж ухааран залгаж унших ажаамуу. Үүнээс хойш, тоо тавьж товчлохыг зогсож, эцгийнх нь нэрийг давтан бичиж залгав. Үзэхэд арай хялбар болов уу гэж бодлоо. Ингэхэд, хүүхдийнх нь нэр тод хараар байх болно.

ᠡ Одоо, Японд олдсон Сэцэн хан Шолойн Угийн бичгийг Монголынхтой зэргэцүүлэн, хэрхэн тохирч байгаа, бичлэгийн зөрөө зэргийг нэлээд жишээгээр бодтойгоор толилуулая ↓

Японы NHK телевизээр нэвтрүүлэн буй Угийн бичигт тодоос тод харагдаж буй

ᠰᠡᠴᠡᠨ ᠬᠠᠩ ᠰᠣᠯᠠᠢᠨ ᠤᠭᠢᠨ бичигт 5 хүн нэг айлын хүүхдүүд байна.

Монгол Улсын Үндэсний номын санд 79347\695 ба 7934.\7994 дансны дугаартай хадгалагдан буй Сэцэн хан Шолойн Угийн бичгээс хайв. Монголд судалгаа, аль хэдийн, 1964 оноос эхлэхисэн, илтгэгчийн хэд хэдэн бүтээл нэгэнт гарчихсан, нэрсийн бүгд хэлхээг нь хийж, хэвлэлд бэлтгэхисэн байсан тул, тун төвөггүй олов. Ёстой л “сахлын будаа”(*амар, хялбар*) байлаа. Үүнд:

ᠰᠡᠴᠡᠨ Pungčuu Пунцаг нь, Монгол Улсын номын сан дахь 79347\695 тоот данснаа бүхүй Сэцэн хан

Шолойн Угийн бичигт Бөрт Чоноос 47-р үе, Чингис Хаанаас 24-р үе, Шолойгоос 6-р үеийн **1676-р** (*судлаачийн өгсөн дугаар. Энэ дугаар давтагдахгүй*) хүн байна.

ᠪᠠᠳᠤᠮᠤᠨᠤᠨᠭᠦᠬᠡ BatumÖngke БатмӨнх нь, Монгол Улсын номын сан дахь 79347\695 тоот данснаа бүхүй Сэцэн хан Шолойн Угийн бичигт Бөрт Чоноос 47-р үе, Чингис Хаанаас 24-р үе, Шолойгоос 6-р үеийн **1677-р** (*судлаачийн өгсөн дугаар. Энэ дугаар давтагдахгүй*) хүн байна.

ᠵᠠᠩᠭᠢ Jangiy –a Зангиа! нь, Монгол Улсын номын сан дахь 79347\695 тоот данснаа бүхүй

Сэцэн хан Шолойн Угийн бичигт Бөрт Чоноос 47-р үе, Чингис Хаанаас 24-р үе, Шолойгоос 6-р үеийн **1678-р** (*судлаачийн өгсөн дугаар. Энэ дугаар давтагдахгүй*) хүн байна.

ᠴᠣᠶᠤᠯᠠᠩ Cоyлон Цоглон нь, Монгол Улсын номын сан дахь 79347\695 тоот данснаа бүхүй


Сэцэн хан Шолойн Угийн бичигт Бөрт Чоноос 47-р үе, Чингис Хаанаас 24-р үе, Шолойгоос 6-р үеийн **1679-р** (*судлаачийн өгсөн дугаар. Энэ дугаар давтагдахгүй*) хүн байна.

ᠴᠣᠶᠢᠳᠣᠭ Cоyidoᠭ, Чойдог нь, Монгол Улсын номын сан дахь 79347\695 тоот данснаа бүхүй

Сэцэн хан Шолойн Угийн бичигт Бөрт Чоноос 47-р үе, Чингис Хаанаас 24-р үе, Шолойгоос 6-р үеийн **1680-р** (*судлаачийн өгсөн дугаар. Энэ дугаар давтагдахгүй*) хүн байна.



Японд олдсон эхийн хэсэг



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79347\695)ийн хэсгээс



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79347\695)ийн хэсэг.
Батмөнхийн **Тунгалагийн** авсан зураг


Ингээд, дээрхи ах дүү таван хүнээр төлөөлүүлэн, сэцэн хан Шолойгоор дашлуулан, **Чингис Хаан** хүртэлхи уг эхийг гаргаж үзүүлье:

 Činggis qayan(1-23-108)

↑
 Tolui(1-24-123)
↑
 Qubilai(1-25-176)
↑
 Činggim(1-26-252)
↑
 Darmabala(1-27-375)
↑
 Qayisang(1-28-483)
↑
 Küslen(1-29-573)
↑
 Toyon Temür(1-30-618)
↑
 Usqal(1-31-654)
↑
 Qaryučay(1-32-668)
↑
 Aǰ i(1-33-685)
↑
 Aǰbarǰ i(1-34-695)
↑
 Qaryučay(1-35-706)
↑
 Bayangmōngke(1-36-712)
↑
 Batumōngke(1-37-719)
↑
 Gersengǰ e(1-38-749)
↑
 Amin Dural(1-39-786)
↑
 Muuru Buyima(1-40-864)

↑
 Šoloi(1-41-979)

↑
 Mičiri(79347-42-2)
↑
 Saǰ ei(79347-43-14)
↑



Японд олдоод байгаа Угийн бичигт байгаа бүх хүний удмыг, Монгол Улсын номын сан дахь Угийн бичигт тулгуурлан энэ мэт бүрнээ гаргаж ирж болно (хэвлэлд шилжих гэж буй номоос нэхэн үзнэ үү).

Энэ удаа, дээр өгүүлснээ **батлан**, Япон дахь Шолойн Угийн бичигт буй 40 хүний төрсөн эцэг (бүдэг, хол тасархай байгаа, харуут үл мэдэгдэх)ийг олж тодруулан толилуулая:

- ᠬᠦᠭᠦᠷᠭᠡ Güürgei Гүүргэй (79347-47-1681) ⇒ Gombu(79347-46-750)-yin köbegün
- ᠭᠣᠩᠴᠠᠭ Gongčuy Гончиг (79347-47-1682) ⇒ Gombu(79347-46-750)-yin köbegün
- ᠯᠠᠭᠭᠦᠵᠠᠪ Pungčuydasi Пунцагдаш (79347-47-1683) ⇒ Wampil(79347-46-751)-un köbegün
- ᠶᠤᠮᠵᠠᠪ Yümjab Юмжав (79347-47-1684) ⇒ Wampil(79347-46-751)-un köbegün
- ᠴᠡᠪᠭᠡᠳᠣᠷᠵᠢ Čebegdorji Цэвэгдорж (79347-47-1685) ⇒ Wampil(79347-46-751)-un köbegün
- ᠪᠠᠨᠴᠢᠨ Wangčün Ванчин (79347-47-1686) ⇒ Dasidongdub(79347-46-754)-un köbegün
- ᠴᠡᠷᠢᠨᠵᠠᠪ Čerinjab Цэринжав (79347-47-1687) ⇒ Eringčin(79347-46-757)-ü köbegün
- ᠯᠠᠭᠭᠦᠵᠠᠪ Pungčuy Пунцаг (79347-47-1688) ⇒ Eringčin(79347-46-757)-ü köbegün
- ᠪᠠᠳᠤᠵᠢᠷᠭᠠᠯ Batujiryal Батжаргал (79347-47-1689) ⇒ Eringčin(79347-46-757)-ü köbegün
- ᠳᠠᠰᠢᠳᠣᠩᠳᠤᠪ Dasidondub(79347-47-1690) ⇒ Jimbaĭab(79347-46-758)-un köbegün
- ᠯᠠᠮᠤᠵᠠᠪ Lhamuĭab Лхамжав(79347-47-2847) ⇒ Čedenĭab(79347-46-1501)-un köbegün
- ᠭᠣᠮᠪᠣᠵᠠᠨ Gombuĭ ab Гомбожав (79347-47-1692) ⇒ Bayingĭ uur(79347-46-761)-un köbegün
- ᠴᠡᠷᠢᠨᠳᠠᠰᠢ Čerindasi Цэриндаш (79347-47-1693) ⇒ Bayingĭ uur(79347-46-761)-un köbegün
- ᠭᠡᠨᠳᠡᠨᠵᠠᠪ Gendü nĭ ab Гэндэнжав (79347-47-1694) ⇒ Bayingĭ uur(79347-46-761)-un köbegün
- [Jb(79347-47-1695) яп. Dasij ab ᠳᠠᠰᠢᠳᠣᠩᠳᠤᠪ ⇒ Güriĭ ab(79347-46-762)-un köbegün
- [J(79347-47-1696) яп. Čerindasi ᠴᠡᠷᠢᠨᠳᠠᠰᠢ ⇒ Čenggünĭ ab(79347-46-763)-un köbegün
- ᠴᠢᠪᠠᠶ Ćibay Чибаг (79347-47-1697) яп. Lhačün ᠯᠠᠬᠠᠴᠢᠨ ⇒ Čenggünĭ ab(79347-46-763)-un köbegün
- ᠴᠡᠳᠡᠨᠵᠠᠪ Čedenĭ ab Цэдэнжав (79347-47-1698) ⇒ Čenggünĭ ab(79347-46-763)-un köbegün
- beyiseo ᠭᠣᠩᠴᠠᠭᠢᠨ Gongčuyĭ ab Гончигжав(79347-47-1699) ⇒ Idamĭ ab(79347-46-764)-un köbegün
- ᠭᠣᠩᠴᠠᠭᠢᠨ Гончиг Gongčuy(79347-47-1700) ⇒ Idamĭ ab(79347-46-764)-un köbegün
- [Jmay-a(79347-47-1701) яп. [Jhmay-a ⇒ Idamĭ ab(79347-46-764)-un köbegün
- ᠴᠡᠷᠢᠨᠳᠠᠰᠢ Čerindasi Цэриндаш (79347-47-1702) ⇒ Idamĭ ab(79347-46-764)-un köbegün
- ᠴᠡᠷᠢᠨᠳᠣᠷᠵᠢ Čerindorĭ i Цэриндорж(79347-47-1703) яп. ᠳᠠᠰᠢᠳᠣᠩᠳᠤᠪ ⇒ Idamĭ ab(79347-46-764)-un köbegün
- ᠪᠠᠳᠤ Batu Бат(79346-51-11761) ⇒ ĭ amsarin(79346-50-10079)-un köbegün
- ᠴᠢᠩᠳᠣᠷᠵᠢ Čingdorĭ i Чиндорж(79346-51-11763) ⇒ ĭ amsarin(79346-50-10083)-un köbegün
- ᠴᠣᠶᠪᠠᠳᠠᠷᠠᠭ Čoybadarqu Цогбадрах(79346-51-11764) ⇒ Manghar(79346-50-10085)-un köbegün

ᠴᠣᠳᠡᠯᠭᠡᠷ ᠴᠣᠭᠳᠡᠯᠭᠡᠷ(79346-51-11765) ⇒ Manghar(79346-50-10085)–un köbegün

ᠭᠣᠮᠪᠠᠪᠠᠴᠠᠷ ᠭᠣᠮᠪᠠᠪᠠᠴᠠᠷ(79346-51-11766) ⇒ Manghar(79346-50-10085)–un köbegün

ᠪᠣᠷᠠᠴᠠᠷ ᠪᠠᠴᠠᠷ(79346-51-11768) ⇒ Boruküü(79346-50-10089)–un köbegün

ᠪᠣᠰᠠᠩ ᠪᠣᠰᠠᠩ(79346-52-12189) ⇒ Čengdebürgüd(79346-51-10890)–un köbegün

ᠷᠠᠳᠠ ᠷᠠᠳᠠ(79346-52-12190) ⇒ Čengdebürgüd(79346-51-10890)–un köbegün

ᠰᠠᠭᠳᠠᠷᠰᠦᠷᠦᠨ ᠰᠠᠭᠳᠠᠷᠰᠦᠷᠦᠨ(79346-52-12217) ⇒ Lubsangdongdub(79346-51-10906

яп. Lubsangdengdüb)–un köbegün

ᠳᠡᠮᠴᠢᠭᠠᠩᠵᠢᠯ ᠳᠡᠮᠴᠢᠩᠭᠠᠨᠵᠢᠯ(79346-52-12194) ⇒ güng–ni ṽ erge ṽ asayᠤ

Damdingdorṽ i(79346-51-10913)–yin köbegün

ᠵᠠᠮᠰᠢᠷᠠᠩᠵᠠᠪ ᠵᠠᠮᠰᠢᠷᠠᠨᠵᠠᠪ(79346-52-10536) ⇒ güng–ni ṽ erge ṽ asayᠤ

Damdingdorṽ i(79346-51-10913)–yin köbegün

ᠲᠣᠵᠢᠰᠦᠷᠦᠨ ᠲᠣᠵᠢᠰᠦᠷᠦᠨ(79346-52-12197) ⇒ güng–ni ṽ erge ṽ asayᠤ

Damdingdorṽ i(79346-51-10913)–yin köbegün

ᠳᠣᠷᠵᠢᠭᠣᠲᠤᠪ ᠳᠣᠷᠵᠢᠭᠣᠲᠤᠪ(79346-52-12199) ⇒ Čerindondub(79346-51-10916


яп. Čerindengdüb)–un köbegün

ᠳᠠᠰᠢᠳᠡᠯᠭᠡᠳ ᠳᠠᠰᠢᠳᠡᠯᠭᠡᠳ(79346-52-12200) ⇒ Čerindondub(79346-51-10916

яп. Čerindengdüb)–un köbegün

ᠲᠦᠮᠡᠩᠭᠦᠷᠵᠢ ᠲᠦᠮᠡᠨᠭᠦᠷᠵᠢᠯ(79346-52-12201) ⇒ Čerindondub(79346-51-10916

яп. Čerindengdüb)–un köbegün



Лувсан

Японд олдсон эхийн хэсэг. ᠵᠠᠮᠰᠢᠷᠠᠩᠵᠠᠪ

Nawangyalsang(79346-49-5796)

Наваангалсан ↓

ᠰᠠᠩᠵᠠᠶᠢᠳᠣᠷᠵᠢᠯ ᠰᠠᠩᠵᠠᠶᠢᠳᠣᠷᠵᠢᠯ(79347-48-3631)yin köbegün

гэх мэтээр, японд олдсон Шолойн Угийн бичгийн бүх хүний нэрийг уншиж, өвөг дээдэс болох Чингис Хаан, БөртЧонотой нь холбон толилуулах боломжтой.


Харин, бид судлаачдад “аль нь уг эх нь вэ?”, “аль нь түрүүчийнх вэ?”, “аль нутгийн бичиг вэ?” гэдгийг тодруулах тун бэрх асуудал тулгарч байна. Үүнийг хагалан, нэг мөр болгохын тул илүү

нарийвчилсан судалгаа, цаг хугацаа шаардлагатай. Ингэхэд, нэгэн чухал бөгөөд чухаг, сонирхолтой тэмдэглэл байна, үүнд:

Монголд байгаа 79346\7994 дансны дугаартай Шолойн угийн бичгийн ар талд, хуруун

чинээ муутуу цаасан дээр “~~ᠮᠣᠩᠭᠣᠯ~~ ~~ᠨᠠ~~”(ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠨᠠ, ҮЛДЭХ ЭХ) гэж бичээд


наачихсан байгаа нь, хувиран олшруулж, өөр газар илгээсний баталгаа болох нь лавтай. Түүнийг зураг буулгалаар толилуулая ♪



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79346\7994)ийн ар талд буй тэмдэглэл.
Б.Сумьяабаатарын авсан зураг



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79346\7994)ийн хэсэг.
Батмөнхийн **Тунгалагийн** авсан зураг



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79346\7994)ийн хэсэг.
Батмөнхийн **Тунгалагийн** авсан зураг



Монгол дахь Шолойн Угийн бичиг(79347\695)ийн хэсэг.
Батмөнхийн **Тунгалагийн** авсан зураг



Пүрэвийн **Батчулуун**ы авсан зураг

2025.04.27. Ням гараг. 17⁰²